ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО.

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН БАРИЛГА

УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

Бүлэг :

1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА (ТЕШ)

❖ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

2. ТЕХНИКИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА (ТТШ)

- БАРИЛГА АРХИТЕКТУРЫН АЖИЛ
- БАРИЛГЫН ҮНДСЭН БҮТЭЭЦИЙН АЖИЛ
- ХАЛААЛТ, САЛХИВЧИЙН АЖИЛ
- ЦАХИЛГААНЫ АЖИЛ
- ЦЭВЭР, БОХИР УСНЫ АЖИЛ
- ХОЛБОО, ДОХИОЛЛЫН АЖИЛ
- ЛИФТНИЙ АЖИЛ

ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

❖ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Баримт бичгийн өөрчлөлтийн тэмдэглэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн тайлбар	Огноо	Бэлтгэсэн
R0	Эхний баримт бичиг	2025.02.24	Б.Чулуунцэцэг

Товчилсон үгийн тайлбар

ЕГ	Барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгч/ ГҮЙЦЭТГЭГЧ
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ТХН	Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
ЗТЗ	Зураг төсөл зохиогч
ТГ	Туслан гүйцэтгэгч
ТЕШ	Техникийн ерөнхий шаардлага
ТТШ	Техникийн тусгай шаардлага
ИГД	Инженер геологийн дүгнэлт
БУА	Барилга угсралтын ажил
ГША	Газар шорооны ажил
ТББ	Төмөр бетон бүтээц
ИШС	Инженерийн шугам сүлжээ
БАА	Барилга Архитектурын ажил

ГАРЧИГ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Төслийн бичиг баримт
1.2. Төслийн байршил
1.3. Талбайн нөхцөл

2. ГЭРЭЭТ АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

2.1. Ерөнхий
2.2. Түр барилга байгууламж, холболт
2.3. Барилгын угсралтын ажил
2.4. Зам талбайн ажил
2.5. Бусад ажил үүрэг

3. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Хууль тогтоомж, барилгын норм стандарт
3.2. Хөдөлмөр хамгаалал, техникиин аюулгүй ажиллагаа
3.3. Талбайн зохион байгуулалт
3.4. Барилгын хамгаалалтын хашаа
3.5. Мэдээллийн самбар
3.6. Барилгын хог хаягдалын зохицуулалт
3.7. Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ
3.8. Эрүүл ахуйн зохицуулалт
3.9. Түр барилга байгууламжийн зохицуулалт
3.10. Барилгын хамгаалалтын хашлага
3.11. Галын аюулгүй байдал
3.12. Хувийн хамгаалалтын хэрэгсэл
3.13. Тээврийн зөвшөөрөл авах
3.14. Ажлын гүйцэтгэлийн тайлагнал

4. УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ШААРДЛАГА

4.1. Хууль тогтоомж
4.2. Удирдах ажилтаны чадвар
4.3. Эрүүл мэндийн үйлчилгээ
4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт
4.5. Жендерийн бодлого
4.6. Удирдах ажилтаны ерөнхий шаардлага
4.7. Бүтэн цагаар ажиллах удирдах болон техникийн ажилтаны жагсаалт

5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМЫН ШААРДЛАГА

5.1. Хууль, тогтоомж, стандарт
5.2. Хяналт, шалгалт, аюулгүй ажиллагаа
5.3. Цамхагт краны шаардлага
5.4. Ган татлагатай дүүжинт өргүүрийн /люлька, тавцан/ шаардлага
5.5. Бусад тоног төхөөрөмжийн жагсаалт
5.6. Тээврийн зөвшөөрөл авах

6. АЖИЛ ЭХЛЭХ, ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ
6.1. Ажил эхлэх зөвшөөрөл
6.2. Тэг тэнхлэг тавих
6.3. Ажил гүйцэтгэх төлөвлөгөө
6.4. Ажил гүйцэтгэх аргачлал
6.5. Чанарын хяналтын төлөвлөгөө
6.6. Барилгын үе шатны ажлын зөвшөөрөл
7. АЖЛЫН ЗУРАГ, ТӨСЛИЙН БИЧИГ БАРИМТ
7.1. Талбайн бичиг баримт
7.2. Гүйцэтгэгчийн бичиг баримт
7.3. Гүйцэтгэгчийн хийх зураг
8. МАТЕРИАЛЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ
8.1. Стандарт
8.2. Материал тоног төхөөрөмж /Загвар/ батлуулах
8.3. Гүйцэтгэлийн загвар батлуулах
8.4. Батлагдаагүй загвар
8.5. Материалын хадгалалт хамгаалалт
9. ЧАНАРЫН ХЯНАЛТ
9.1. Тест, туршилтууд
9.2. Хэмжилт
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛГӨӨ (Г-БОМТ)
10.1. Зорилго
10.2. Тавигдах шаардлага
10.3. Тайлагнал
10.4. Бусад шаардлагууд
11. ДААТГАЛ
12. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ
12.1. Гэрээний үнэ
12.2. БУА-ын тоо хэмжээ, үнийн санал
12.3. Гэрээний үнэд орох бусад зардал

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү техникийн ерөнхий шаардлагад тус төслийн Нийслэлийн түргэн тусламжийн төвийн барилгын иж бүрэн барилга угсралтын ажлын Гүйцэтгэгчийн (ЕГ-Ерөнхий Гүйцэтгэгч) ажлын цар хүрээ, зохион байгуулалтын болон угсралтын үйл явцад тавигдах хяналтын шаардлагуудыг тусгасан болно.

1.1. Төслийн бичиг баримт

АХБ-ны хөрөнгө оруулалтаар баригдах Нийслэлийн түргэн тусламжийн төвийн барилгын зураг төслийн боловсруулахад дараах баримт бичгүүдийг ашигласан болно. Үүнд:

- Архитектур төлөвлөлтийн МЗХ2024/02-006 тоот даалгавар
- Зураг төсөл боловсруулах дугаар ЗД-ЭМЯ02/24 тоот ажлын даалгавар /Эрүүл Мэндийн Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12-р сарын 10-ны өдөр баталгаажуулсан/;
- Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан загвар зураг.
- “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ний №571/2024 тоот дулааны техникийн нөхцөл;
- Ус сувгийн удирдах газрын №732/24 тоот цэвэр, бохир усны техникийн нөхцөл;
- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК -ний №01/05878/24 тоот цахилгааны техникийн нөхцөл
- “Мэдээлэл холбоо сүлжээ” ХХК-ний №B-U2024/1000 тоот холбооны техникийн нөхцөл

Барилгын ажил гүйцэтгэх явцад шаардлага үүссэн тохиолдолд гүйцэтгэгчийн ирүүлсэн албан хүсэлтэд үндэслэн дээрх баримт бичгүүдийн хуулбарыг Захиалагчаас өгнө.

1.2. Төслийн байршил

Түргэн тусламжийн төвийн барилга нь зохих зөвшөөрлийн дагуу Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт төлөвлөсөн. Одоо байгаа Түргэн тусламжийн төвийн эзэмшлийн газарт багтаан тухайн орчны барилгууд, тэдгээрийн зам талбай, орц гарцуудтай уялдуулан

Зураг 1. Байршлын схем

1.3. Талбайн нөхцөл

Барилга барих талбайд инженер-геологийн судалгааны ажлыг Инженер-геологи, геотехникийн судалгааны ажлын техникийн даалгаврын дагуу “Жоншт-Уул” ХХК хийж гүйцэтгэж, Архив №-3037 дугаартай судалгааны тайланг магадлалаар баталгаажуулсан. Судалгааны талбайд 6.0м-н гүнтэй 3 цооног өрөмдөж хөрсний шинж чанарыг тодорхойлсон. Барилга баригдах талбай нь инженер геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэйд тооцогдоно.

Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын явцад барилга угсралтын ажлын талбайд цаг уурын үзэгдлээс (бороо, мөндөр, цас, салхи, аянга г.м) болж үүсэх бүх эрсдэлийг тооцож, хамгаалах бүхий л арга хэмжээг авч, үүссэн хохирлыг бүрэн хариуцна.

2. ГЭРЭЭТ АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

2.1. Ерөнхий хариуцах ажил

Гүйцэтгэгч нь (Ерөнхий Гүйцэтгэгч гэх) ажлын цар хүрээ, шаардлагыг бүрэн гүйцэт ойлгох үүднээс энэхүү ТЕШ-аас гадна ТТШ, иж бүрэн зураг төсөл, барилгын талбайн ИГД-тэй сайтар танилцсан байх шаардлагатай.

Гүйцэтгэгч нь зураг төсөл болон ТТШ-д тусгагдсан, эс тусгагдсанаас үл хамаарч барилга угсралтын ажлын үе шат бүрийг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм дүрмийн шаардлагын дагуу зохих ёсоор хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлыг аюул осолгүй гүйцэтгэх, түүнд чанарын хяналт хийж чанарын баталгаа гаргах ажилтай холбоотой, 2.3, 2.4 –д заасан бүх материал, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хариуцана.

Зураг төсөл, ТЕШ, ТТШ-ын хооронд зөрөө гарсан бол, Захиалагч өөрөөр шийдсэнээс бусад тохиолдолд, аль илүү өндөр шаардлагыг мөрдөж ажиллана.

Төлөвлөж буй барилга нь шугам сүлжээний давхцалтай талбайд байрлаж буй тул барилгын ажил эхлэхийн өмнө, талбайд давхцаж буй гадна шугам сүлжээний шугамуудыг техникийн нөхцлийн дагуу шилжүүлэн барилгын талбайг бэлдэнэ.

Ерөнхий гүйцэтгэгч нь барилгын угсралтын ажлын хүрээнд, дараах ажлуудыг, батлагдсан зураг төсөл, ТТШ-ын шаардлагын дагуу хийж гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруулна. Үүнд:

2.2. Түр барилга байгууламж, холболт

- Түр барилга байгууламж, тэдгээрийн ашиглалт
- Түр ИШС, түр гэрэлтүүлэг тэдгээрийн ашиглалт
- Барилгын талбайн инженерийн бэлтгэл
- ХАБЭА-н арга хэмжээ, талбайн цэвэрлгээ, хог зайлуулах
- Тест туршилтууд
- Хүйтний нөхцөлд авах арга хэмжээ
- Түр барилга байгууламж: барилгын хашаа, Захиалагчийн оффис, хурлын өрөө, анхны тусламжийн өрөө, сургалтын өрөө, талбайн лаборатори тоног төхөөрөмж, харуулын байр, нэгдсэн гал тогоо
- Түр ИШС: Түр техникийн нөхцөл авах, ерөнхий цахилгаанд дэд өртөө, цэвэр усны эх үүсвэрийн цэг, бохир усны цэг байгуулах

2.3. Барилгын Угсралтын Ажил

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн барилгын ажлын зураг төсөлд тусгагдсан бүх ажлыг гүйцэтгэнэ. Тус барилга нь тэнхлэгээр 48.5x10.4 метрийн хэмжээтэй газраас дээш 3 давхар, зоорьтой нийт 2220,35м^2 талбайтай, хуучин барилгатай холбосон хүзүүвч зэргээс бүрдэнэ. Барилга угсралтын ажилд дараах ажлууд багтах бөгөөд үүгээр хязгаарлагдах бусад холбогдох ажлууд орно.

- Газар шорооны ажил
- Төмөр бетон бүтээцийн ажил
- Лифтний угсралт, тохируулга
- Фасадын иж бүрэн системийн угсралтын ажил
- Газардуулга, аянга зайлуулагч
- Бетон шал, тэгшилгээний ажил
- Барилга Архитектурын ажил: гадна дотор ханын өрлөг, дулаалга, ус тусгаарлагч, фасад, дээвэр, хаалга цонх гэм мэт.
- Дотор инженерийн шугам сүлжээ
- Дотор заслалын ажил
- Дотор Хийн хангамж
- Халаалт, агаар сэлгэлт, хөргөлт
- Гал эсэргүүцэх систем
- Хуучин барилгатай холбох буулгалт, засварын ажил

2.4. Зам Талбайн Ажил

Барилгын гол орцыг баруун зүгрүү төлөвлөсөн, туслах орцыг хойд болон зүүн зүгт байрлуулсан, барилгын хойд талаар туслах замыг төлөвлөж өгсөн. Мөн одоо байгаа өргөтгөлийн барилгатай 2-р давхраар хүзүүвчээр холбогдохоор төлөвлөсөн. Явган хүний зам, орцууд, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөтөч зам, тэргэнцэрийн пандусуудыг нормын дагуу төлөвлөсөн.
Шинээр хийх зам талбайд гэрэлтүүлэг, сандал, хогийн сав, ногоон байгууламж зэргийг төлөвлөсөн.

- Барилга руу орох гарах авто зам, зогсоолын ажил
- Барилгын эргэн тойронд төлөвлөгдсөн явган зам
- Барилгын эргэн тойронд зурагт төлөвлөгдсөн талбайд зүлэгжүүлэлт
- Гадна гэрэлтүүлэг
- Гадна тохижилт
- Гадна зам талбай, барилгын зугтах гарц ба бусад хэсэгт холбогдох норм, дүрэм болон стандартын дагуу байрлуулах шаардлагатай бүх таних тэмдэг, (анхааруулах, заах, хориглох, мэдээлэх болон нэмэлт) тэмдэглэгээ, хаяг зэргийг ханган нийлүүлж, угсрах

2.5. Бусад Ажил Үүрэг

Нэрлэгдсэн болон томилогдсон туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч нарыг мэдээллээр хангаж, өөрийн хариуцсан барилгын төлөвлөгөөтэй уялдуулан хамтран ажиллах, тэдгээрийн ажилд чанарын хяналт тавих

- Төрийн холбогдох хууль, хяналтын байгууллагын хяналт шалгалтын дагуу ажлыг зохион байгуулах
- Шаардлагатай нарийвчилсан ажил гүйцэтгэх, гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулах
- Туслан гүйцэтгэгч, Нэрлэгдсэн ханган нийлүүлэгчийн ажлын гүйцэтгэлд чанарын хяналт тавих

- Ажил гүйцэтгэх аргачлал боловсруулах, туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх, хяналт тавих
- Материал, тоног төхөөрөмжийн загвар болон загварын гүйцэтгэл батлуулах
- Материал тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт
- Гүйцэтгэлийн зураг, ил далд ажлын акт, ажлын журнал хөтлөх
- Ашиглалтын зааварчилгаа бэлдэж хүлээлгэж өгөх
- Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгөх
- Хог хаягдлыг тогтмол зайлуулах
- Сүүлийн цэвэрлэгээ хийх

3. БАРИЛГЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэгч нь барилгын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь байнгын ашиглалтад өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай.

3.1. Хууль тогтоомж, барилгын норм стандарт

Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ "Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт" БНбД 12-01-09, “Барилгын үйлдвэрлэлийн технологи зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар” БД 12-104-11 зэргийг чандлан мөрдөж ажиллана. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.2. Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа

Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаандаа “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. I хэсэг. Ерөнхий шаардлага БНбД 12-03-04”, “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм БНбД 12-04-06”, “Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05” зэрэг ХАБЭА-н шаардлагыг чанд мөрдөн ажиллах ба тэдгээр шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг бүрэн хариуцна.

Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг тогтмол өгч ажиллана. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаагүйгээс үүдэн гарах аливаа хор хохирлыг өөрсдөө бүрэн хариуцна.

3.3. Талбайн зохион байгуулалт

Барилгын ажлыг гүйцэтгэхийн өмнө “БАРИЛГЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ” БНбД 12-01-09–н дагуу гүйцэтгэгч талбайн зохион байгуулалтын зураг төслийг /түр хашаа, барилга байгууламж, инженерийн хангамж болон техник хэрэгслийн орц гарц, замын тэмдэглэгээ бүхий/ барилгын талбайг хүлээн авч ажил эхлэхээс 7 хоногийн өмнө гүйцэтгэж захиалагч болон мэргэжлийн байгууллагаар хянуулж батлуулсан байна.

Гүйцэтгэгч нь талбай цэвэрлэх, барилгажилтад бэлтгэх ажлыг хийхдээ БНбД 3.01.06-90 “Барилгын орчны тохижилтын ажил”-н 2 дугаар бүлэг болон БНбД 12-01-09 “Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт”-н 5.2, 5.3, 5.4 дүгээр заалтуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь барилгажилтын нийт талбайн хэмжээнд гадаргын ус түр зайлуулах арга хэмжээ авах, барилгын талбайг хашиж хамгаалан, шалган нэвтрүүлэх тогтолцоог бий болгох, барилгын талбай дахь түр ашиглах зам, талбайг барих, барилгын талбайг галын аюулаас хамгаалах тогтолцоог бий болгох шаардлагатай.

3.4. Барилгын хамгаалалтын хашаа

Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын үед хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хангах зориулалтаар түр хашааг барина. Түр хашааг барихдаа замын уулзвар үзэгдэх орчныг хязгаарлахгүй. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолын хавсралт “Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах” журам, “Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага” UCS0001-01:2019 стандарт, “Барилгын талбайн түр хашаа” MNS 5414:2004; “Хамгаалах хашлага” MNS 12.4.007:1981-ийг мөрдлөг болгон ажиллана. Дээрх журам болон стандартын шаардлагууд хоорондоо зөрсөн тохиолдолд аль өндөр шаардлагатайг нь дагаж мөрдөнө. Барилга угсралтын ажлын түр хашаа нь өнгө үзэмж сайтай, эвдрэл гэмтэлгүй байна. Хашааны шон хоорондын зай нь 1.2, 1.6, 2.5 м байж болох ба 6.0 метрээс ихгүй байна. Түр хашаа цайвар саарал болон цагаан өнгөтэй (RGB 204, 204, 204) байна. Түр хашааны шонг газарт зоох боломжгүй тохиолдолд тулаас бүхий хүндрүүлэгч дээр суурилуулна. Хашааны шонг 1м хүртэл гүнд суулгана.



Зураг 2. Түр хашааны бэхэлгээ, суурилуулалт /UCS0001-01:2019/

3.5. Мэдээллийн самбар

Гүйцэтгэгч нь барилгын талбай эзэмшсэнээс хойш 1 долоо хоногоос хэтрэхгүй хугацаанд Захиалагчаас чиглэл өгсний дагуу төслийн таних тэмдэг бүхий самбарыг 1000x2000 мм-ийн хэмжээтэй хийж, ажил гүйцэтгэх талбайн хэсэгт байрлуулна. Мэдээллийн самбарт тухайн захиалагч болон гүйцэтгэгчийн нэр, батлагдсан ерөнхий төлөвлөгөө, талбайн зохион байгуулалтын зураг, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээний зураг, төслийн эхлэх болон дуусах хугацааг тодорхой бичиж яаралтай үед холбогдох барилга угсралтын менежер болон талбайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженерийн овог, нэр, холбоо барих утасны дугаарыг тэмдэглэнэ. Мэдээллийн самбарыг гэрээний хугацаанд бүрэн ашиглагдах хэмжээнд Улаанбаатар хотын цаг агаарын нөхцөлд тохирохуйц бөх бат материалаар хийсэн байх ба хотын стандарт UCS0001-01:2019 “Орчны аюулгүй байдал” Барилга замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлагын 7.1; 7.1.6-р заалтуудыг баримтална. Аюулгүй ажиллагааны тэмдгийг түр хашааны эргэн тойронд байрлуулна.

Зураг 3. Барилгын мэдээллийн самбар /жишээ/

Зураг 4. Аюулгүй ажиллагааны тэмдэг

Зураг 5. Мэдээллийн самбар, аюулгүй ажиллагааны тэмдэг байрлуулах жишиг зураг

3.6. Барилгын хог хаягдалын зохицуулалт

Гүйцэтгэгч нь барилга, тохижилтын хог хаягдлыг нутгийн захиргааны байгууллагын зохих албадтай тохиролцсоноор нэр төрлөөр нь тусгайлан ангилж хаях цэгийг тогтоох бөгөөд барилга угсралтын ажлын талбайд ахуйн, аюултай болон барилгын хог хаягдлын гэж ангилсан хогийн сав байрлуулна. Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажил дууссаны дараа түр барилга байгууламжийг нүүлгэн, гарсан хог хаягдлыг заавал зайлуулна.

Гүйцэтгэгч нь барилгын хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх, хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжийг бүрдүүлэх, барилгын хог хаягдлыг ангилан ялгах ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй нөхцөлөөр хийж хэрэгжүүлэх, хог хаягдлын мэргэжлийн ажилтан ажиллуулах, барилгын энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагаар тээвэрлүүлэх, тээврийн зардлыг бүрэн хариуцах зэрэг ажлуудыг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48-р тушаалын хавсралтаар батлагдсан “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг баримтлан гүйцэтгэнэ. Барилгын хог хаягдлын мэдээллийн санг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/428 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-ын дагуу бүрдүүлнэ. “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-тэй ажиллаж, төлөвлөгөөний тайланг ажил дууссанаас хойш нэг сарын дотор аймаг, Нийслэлийн барилгын салбарын төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

3.7. Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ

Барилгын тухайлсан ажилбар тус бүр дээр ажил гүйцэтгэх төсөл АГТ, технологийн карт ТК, хөдөлмөр процессын карт ХПК зэргийг “Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт” БНбД 12-01-09-н дагуу төлөвлөж хийж гүйцэтгэнэ. "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм" Ерөнхий шаардлага норм дүрмүүдийг дагаж мөрдөх ба Дохионы өнгө, аюулгүйн ажиллагааны тэмдгүүд MNS 12.4.002:85; Авто замын хаалт MNS 6517:2015; Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014; Ачаа тээврийн автомашин болон чиргүүлийн бүтээлэг MNS 6756: 2019 зэрэг стандартуудыг мөн баримтална.

Гүйцэтгэгч нь барилгын ажлын талбайд ажиллагсдыг онцгой байдлын үед цуглуулах цэгийг гаргана. Онцгой байдлын үед шуурхай ажиллах схемийг гаргаж талбайд байршуулна.



Зураг 6. Онцгой байдлын үед ажиллах схем /жишээ/

3.8. Эрүүл ахуйн зохицуулалт

Дулааны улиралд ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ачааллыг багасгах зорилгоор зөөврийн бие засах газар ашигласан тохиолдолд арчлалтыг хариуцах үйлчилгээний компаниудтай гэрээ хийж, гүйцэтгэлийн стандартыг мөрдөж ажиллах шаардлагатай. АЦ блок, угаалтуурын ариун цэвэр, ариутгалыг холбогдох эрүүл ахуйн горимын дагуу тогтмол хийнэ.

Зөөврийн бие засах газрыг цельсийн -10 градусаас хүйтэн нөхцөлд гадна орчинд хэрэглэхгүй. Барилга угсралтын ажлын үед энгийн нүхэн жорлон ашиглахыг хатуу хориглоно.

Гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан талбайд хог хаягдлын цэг, АЦ блок, угаалтуур, тамхи татах цэг зэргийг байгуулна. Хог хаягдлыг ангилж түр хадгалах ба тогтмол зайлуулна. Ахуйн хогийг өдөр тутам, барилгын хогийг 7 хоног тутам зайлуулна. Гүйцэтгэгч нь өөрийн ажиллагсдыг зориулалтын бус газар хог хаягдал хаях, бие засах зэрэгт хатуу хяналт тавин ажиллана. Хоол хийх болон ундны ус нь стандарт эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

3.9. Түр барилга байгууламжийн зохицуулалт

Гүйцэтгэгч нь түр барилга байгууламжийн тоо, хүчин чадлыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын Сайдын 2011 оны 248 дугаар тушаалын хавсралт Барилгын үйлдвэрлэлийн технологи зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах зааврын 4.7-н дагуу тодорхойлж барилгын зохион байгуулалтын төсөл болон барилгын талбайн зохион байгуулалтын зураг төсөлд тусгасан байна.

3.10. Барилгын хамгаалалтын хашлага

Гүйцэтгэгч нь барилгын хамгаалалтын хүрээг өндрөөс биет унахаас сэргийлэх зорилгоор хийнэ. Хамгаалалтын хүрээн дээр унасан хогийг цэвэрлэх ажилчдыг өндрийн бүстэй ажиллуулна. Хамгаалалтын хүрээн дээр хүн явах, материал хураахыг хориглоно. Торны нүхний хэмжээ 80-100мм-ээс багагүй бөгөөд утасны өргөн 4-6мм-ээс багагүй байна.

Гүйцэтгэгч нь барилгын хамгаалалтын хашлагыг өндрөөс хүн унахаас сэргийлэх зорилгоор хийнэ. Хамгаалалтын хашлаганы тор галд тэсвэртэй материалтай байна. Торны нүхний хэмжээ 7.5мм-ээс багагүй байна. Хамгаалалтын хашлагыг барилгын үндсэн бүтээцийн хөдөлгөөнгүй хэсгээс бэхэлнэ. Бэхэлгээ хоорондох зай 6м-ээс ихгүй байна. Хамгаалалтын хашлаганы хийцийн элемент 20кг-аас ихгүй жинтэй байна. Угсралтын шатны өндрийн 10м тутамд амрах тавцан хийнэ. Хамгаалалтын хашлаганы элементүүдийг холбож угсрахад хялбар, эвдэрсэн тохиолдолд солих болон засварлахад энгийн байх шаардлагатай.



Зураг 7. Хамгаалалтын хүрээний харагдах байдал



Зураг 8. Хамгаалалтын хашлаганы харагдах байдал



Зураг 9. Хамгаалалтын хашлаганы бэхэлгээ, суурилуулалт

3.11. Галын аюулгүй байдал

Гүйцэтгэгч нь ХАБЭА-н багийн зааварчилгааны дагуу гал унтраах цэгийг барилгын талбайн зохион байгууллалтын зураг тусгаж, аймгийн Онцгой Байдлыг Газрын байцаагчаар батлуулсаны дагуу гал унтраах цэгийг байгуулах ба шаардлагатай газруудад галын хор байрлуулна. Талбайд ажиллаж буй ажилчид ИТА бүгд нь галын хор ашиглах сургалтанд хамрагдсан байна.

3.12. Хувийн хамгаалалтын хэрэгсэл

Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын талбайд ажиллагсдыг хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангана. Заавал өмсөх хувийн хамгаалах хэрэгсэлд дуулга малгай, ажлын хүрэм, өмд, ажлын гутал, ажлын бээлий, аюулгүйн нүдний шил багтана. Хувийн хамгаалах хэрэгсэлгүй эсхүл насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглоно. Хувийн хамгаалах хэрэгслээр ажилтныг бүрэн хангаагүй болон насанд хүрээгүй хүн ажиллуулснаас үүдсэн хувь хүн болон байгууллагад учирсан хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.

3.13. Тээврийн зөвшөөрөл авах

Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцдаа, хог хаях, бараа материал тоног төхөөрөмж нийлүүлэх, бетон нийлүүлэх зэрэг хотын замаар хүнд машин механизмаар тээвэр хийхэд шаардагдах бүх зөвшөөрлийг авсан байх ба түүнтэй холбоотой хариуцлага, зардлыг бүрэн хариуцна.

3.14. Ажлын гүйцэтгэлийн тайлагнал

Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын явцыг өдөр тутмын, 7 хоног болон сар тутамд магадлах фото зургийн хамт Захиалагч, Хяналтын инженерт урьдчлан тохирсон хэлбэрээр тайлагнана. Магадлах фото зураг болгонд тайлбар бичнэ. Тайлбар бичигт гүйцэтгэсэн ажлын нэр, ажил гүйцэтгэсэн огноо, ажлын байршлын нарийвчилсан тодорхойлолт гэх мэтийг тусгана. Үе шатны ажил бүрийн магадлах фото зургийг авахдаа “Барилга, байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэлийн чанарын хангалт” (Х. Наран, Улаанбаатар хот, 2023 он) номын 9 дугаар бүлгийг жишиг болгон ашиглаж болно.



Зураг 10. Магадлах фото зураг авах жишээ

Ашиглагдаж буй инженерийн шугам сүлжээ бүхий бүсэд ажиллахдаа уг байгууллагын эзэмшигч, өмчлөгч талаас албан ёсны зөвшөөрөл авна. Цахилгаан ба холбоо дохиоллын ашиглагдаж буй шугам сүлжээ огтлолцож буй хэсэгт газар, шугам сүлжээ хариуцсан байгууллагуудаас тодруулга авч нарийн тэмдэглэсний дараа ухлагын ажлыг эхлүүлнэ. Газар шорооны ажлын үед илэрсэн инженерийн шугам сүлжээг эвдэж гэмтээхгүй байх, өвлийн нөхцөлд хөлдөхөөс урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авна.

4. УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, үндэсний хууль тогтоомж, дүрэм журмыг төслийн явцад мөрдөж ажиллах үүрэгтэй. Ингэхдээ Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, Олон улсын байгууллагын үндсэн стандартын дагуу хүүхдийн хөдөлмөр, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхал, бүх төрлийн албадан хөдөлмөрийг хориглох бөгөөд өөрийн ажилтнуудад хөдөлмөрийн тэгш байдлыг хангаж ажиллана.

4.1. Хууль тогтоомж, зөвшөөрөл

БУА-ын Гүйцэтгэгч болон түүний ажиллагсад нь тухайн ажлын зураг, ТЕШ, ТТШ-ын дагуу гүйцэтгэх ур чадвартайг илтгэсэн бүх тусгай зөвшөөрөл, мэргэжлийн диплом, зэрэг, мэргэжлийн үнэмлэхтэй байх шаардлагатай.

4.2. Удирдах ажилтаны чадвар

Удирдах болон техникийн боловсон хүчнүүд бакалавраас дээш зэрэгтэй, аман болон бичгийн харилцааны өндөр боловсролтой, цаг ашиглалт бүтээмж өндөр, ажлын ачаалал даах, ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэх чадвартай, төслийн удирдлагыг хэрэгжүүлэх чадвартай, AutoCAD, Microsoft Office, Microsoft Project, REVIT зэрэг барилга угсралтын ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн болон хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн, ашиглан ажил гүйцэтгэсэн туршлагатай байх шаардлагатай.

4.3. Эрүүл мэндийн үйлчилгээ

Гүйцэтгэгч нь барилгын талбайд өөрийн ажилчдад зориулан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг хангаж ажиллана. Гүйцэтгэгч нь барилгын талбайд хангалттай хэмжээгээр, хангалттай эм хэрэгсэл бүхий анхны тусламжийн хайрцгийг хүн чөлөөтэй хүрэх газар байрлуулна.

Гүйцэтгэгч нь анхны тусламж үзүүлэх сургалтанд хамрагдсан, зохих ур чадварын эзэмшсэн дор хаяж нэг хүнийг тогтмол ажиллуулна. Анхны тусламж үзүүлэхээр томилогдсон хүнийг бүх ажиллагсдад танилцуулсан байна. Ингэхдээ эрүүл мэндийн түр хэсэг байгуулах эсвэл тухайн хорооны эрүүл мэндийн байгууллагатай гэрээлэн ажиллаж болно.

4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт

Гүйцэтгэгч байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер нь төслийн бүхий л үе шатанд барилгын талбай дээрх хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь дотоод ХАБЭАыг зохион байгуулах тогтолцоо, талбайн журмыг ирүүлж хянуулна.
Удирдах болон техникийн боловсон хүчнүүд нь хариуцсан ажил бүртээ ХАБЭА-н хууль, холбогдох норм ба дүрэм, стандарт, заавар, барилга угсралтын ажлын талбайн ХАБЭА-н дүрмийн дагуу шаардлага, зөвлөгөө өгч, арга зүйн туслалцаа үзүүлэн биелэлтийг биечлэн шалгах үүрэгтэй.

4.5. Жендерийн бодлого

Азийн Хөгжлийн Банкны Жендерийн бодлогын дагуу гүйцэтгэгч нь барилгын талбайд хөдөлмөрийн бэрхшээлтэй болон эмэгтэй ажилчдад шаардлагатай бүхий л нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.
Барилга угсралтын ажлын талбайд нийт ажиллагсад Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 10-ний өдрийн 16 тоот тушаалаар батлагдсан Монгол улсын үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт YAMAT-08-д заагдсан үүргүүдийг гүйцэтгэх чадвартай байна. Үүнийг голлох инженерийн техникийн ажиллагсдад тавигдах хамгийн бага шаардлага гэж үзнэ.

4.6. Удирдах ажилтаны ерөнхий шаардлага

Удирдах болон техникийн боловсон хүчнийг барилга угсралтын ажлын график төлөвлөгөөтэй уялдуулан талбайд байлгах шаардлагатай ба тэдгээр нь бүтэн цагаар барилга угсралтын ажлын талбайд байршиж ажиллана. Удирдах болон техникийн боловсон хүчин буюу Төслийн менежер, Барилга угсралтын менежер, Ерөнхий инженер, гол инженер-техникийн боловсон хүчнийг худалдан авах ажиллагааны баримт бичигт мэдүүлсэн дагуу барилга угсралтын ажлыг дуустал ажиллуулах үүргийг Гүйцэтгэгч хүлээх ба зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тохиолдолд Захиалагчид албан бичгээр тэдгээр ажилчдыг солих хүсэлт илгээж зөвшөөрөл авах шаардлагатай. Энд хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийг Татварын ерөнхий хуулийн 6 дүгээр зүйлийн 6.1.41-д тодорхойлж зааснаар ойлгоно.

Гүйцэтгэгч нь 5-с доошгүй жилийн ажлын туршлагатай, дор хаяж 3-5 ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагатай ажлыг удирдан зохион байгуулж, чанарын хяналтыг гүйцэтгэх ИТА багтай байх шаардлагатай.

4.7. Бүтэн цагаар ажиллах удирдах болон техникийн ажилтаны жагсаалт

Доорх хүснэгтэд үзүүлсэн хүний нөөцийн шаардлагатай тоо хэмжээ болон хийж гүйцэтгэх ажлын чиглэл нь хамгийн бага шаардлага гэж үзнэ. Гүйцэтгэгч өөрийн ажлын зохион байгуулалт, төслийн ажлын хуваарьт үндэслэн өөрийн саналыг бүтэц зохион байгуулалтын бүдүүвч болгон ирүүлж, батлуулна. Ажил сайжруулах, гэрээний үүргийг хангуулахад шаардлагатай гэж үзвэл захиалагч барилга угсралтын ажлын талбайд ажиллах шаардлагатай удирдах ажилтаны нөөцийг Гүйцэтгэгчээс нэмж шаардаж болно.

No.	Албан тушаал	Ажлын туршлага [жил]	Ижил төстэй ажлын туршлага [жил]	Хийж гүйцэтгэх ажлын чиглэлийн товч тодорхойлолт
1	Төслийн менежер-1	8	5	Ажлын график, гэрээний зүйл заалттай уялдуулж боловсруулсан төслийн худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулан, захиалагчид танилцуулах, Төслийг төлөвлөсөн хугацаанд, чанартай, үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, удирдлага зохион байгуулалтаар хангах, Төсөлд оролцогч талуудын харилцааг удирдах
2	Барилга угсралтын менежер-1 /Барилгын инженер/	5	3	Барилга угсралтын бүх төрлийн инженерүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, Барилга угсралтын бүх төрлийн ажил гүйцэтгэхэд шаардагдах инженерийн бэлтгэл ажил, материал, багаж тоног төхөөрөмжийн хангамж зэргийг Төслийн менежерээр дамжуулан шийдвэрлэх, Барилга угсралтын бүх төрлийн ажлуудыг уялдуулан төлөвлөх, Ажил эхлэхийн өмнө бүх зөвшөөрлийн баримт бичгийг хянаж, батлах, биелэлтийг биечлэн шалгах, Барилга угсралтын ажлын талбайд ашиглагдаж буй өргөх машин механизмын бүрэн бүтэн байдлыг хариуцагч байх
3	Талбайн инженер-1	5	3	Газар шороо, суурийн болон үндсэн бүтээцийн ажлын нэгжүүдийг (бригадууд) өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, Газар шороо, суурийн болон үндсэн бүтээцийн ажил гүйцэтгэхэд шаардагдах инженерийн бэлтгэл ажил, материал, багаж тоног төхөөрөмжийн хангамж зэргийг Барилга угсралтын менежерээр дамжуулан шийдвэрлэх, Газар шороо, суурийн болон үндсэн бүтээцийн ажлыг гадна болон дотор

				инженерийн шугам сүлжээний угсралтын ажлуудтай уялдуулан төлөвлөх Заслын ажлын нэгжүүдийг (бригадууд) өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, Заслын ажил гүйцэтгэхэд шаардагдах инженерийн бэлтгэл ажил, материал, багаж тоног төхөөрөмжийн хангамж зэргийг Барилга угсралтын менежерээр дамжуулан шийдвэрлэх, Заслын ажлыг үндсэн бүтээцийн болон инженерийн шугам сүлжээний угсралтын ажлуудтай уялдуулан төлөвлөх, Ажил эхлэхийн өмнө бүх зөвшөөрлийн баримт бичгийг хянаж, батлах, биелэлтийг биечлэн шалгах, Хариуцсан ажлуудын ил болон далд ажлын акт үйлдэн, баталгаажуулах, Ажил гүйцэтгэх аргачлал боловсруулах
4	Барилгын бүтээц эдлэлийн технологи инженер-1	5	3	Барилгын үйлдвэрлэлийг хөтлөн явуулах, технологи ба шаардлагад нь нийцүүлэн түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх, технологийн туршилт явуулах
5	Цахилгааны инженер-1	8	3	Барилгын дотор цахилгааны ажлын нэгжүүдийг (бригадууд) өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, Барилгын дотор цахилгааны ажил гүйцэтгэхэд шаардагдах инженерийн бэлтгэл ажил, материал, багаж тоног төхөөрөмжийн хангамж зэргийг Барилга угсралтын менежерээр дамжуулан шийдвэрлэх, Барилгын дотор цахилгааны ажлыг газар шороо, суурь, үндсэн бүтээц, Заслын болон бусад инженерийн шугам сүлжээний угсралтын ажлуудтай уялдуулан төлөвлөх, Ажил эхлэхийн өмнө бүх зөвшөөрлийн баримт бичгийг хянаж, батлах, биелэлтийг биечлэн шалгах, Хариуцсан ажлуудын ил болон далд ажлын акт үйлдэн, баталгаажуулах
6	Халаалт, агаар сэлгэлтийн инженер-1	5	3	Барилгын дотор халаалт, агаар сэлгэлтийн ажлын нэгжүүдийг (бригадууд) өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, Барилгын дотор халаалт, агаар сэлгэлтийн ажил гүйцэтгэхэд шаардагдах инженерийн бэлтгэл ажил, материал, багаж тоног төхөөрөмжийн хангамж зэргийг Барилга угсралтын менежерээр дамжуулан шийдвэрлэх, Барилгын дотор халаалт, агаар сэлгэлтийн ажлыг газар шороо, суурь, үндсэн бүтээц, Заслын болон бусад инженерийн шугам сүлжээний угсралтын ажлуудтай уялдуулан төлөвлөх, Ажил эхлэхийн өмнө бүх зөвшөөрлийн баримт бичгийг хянаж, батлах, биелэлтийг биечлэн шалгах, Хариуцсан ажлуудын ил болон далд ажлын акт үйлдэн, баталгаажуулах

7	Ус хангамж, ариутгах татуургын инженер-1	5	3	Цэвэр бохир ус болон усан хангамж, ариутгах татуургын ажлын нэгжүүдийг (бригадууд) өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, Цэвэр бохир ус болон усан хангамж, ариутгах татуургын ажил гүйцэтгэхэд шаардагдах инженерийн бэлтгэл ажил, материал, багаж тоног төхөөрөмжийн хангамж зэргийг Барилга угсралтын менежерээр дамжуулан шийдвэрлэх, Цэвэр бохир ус болон усан хангамж, ариутгах татуургын ажлыг газар шороо, суурь, үндсэн бүтээц, Заслын болон бусад инженерийн шугам сүлжээний угсралтын ажлуудтай уялдуулан төлөвлөх, Ажил эхлэхийн өмнө бүх зөвшөөрлийн баримт бичгийг хянаж, батлах, биелэлтийг биечлэн шалгах, Хариуцсан ажлуудын ил болон далд ажлын акт үйлдэн, баталгаажуулах
8	Холбоо дохиолол инженер-1	8	3	Барилгын дотор болон гадна холбооны ажлын нэгжүүдийг (бригадууд) өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, Барилгын дотор болон гадна холбооны ажил гүйцэтгэхэд шаардагдах инженерийн бэлтгэл ажил, материал, багаж тоног төхөөрөмжийн хангамж зэргийг Барилга угсралтын менежерээр дамжуулан шийдвэрлэх, Барилгын дотор болон гадна холбооны ажлыг газар шороо, суурь, үндсэн бүтээц, Заслын болон бусад инженерийн шугам сүлжээний угсралтын ажлуудтай уялдуулан төлөвлөх, Ажил эхлэхийн өмнө бүх зөвшөөрлийн баримт бичгийг хянаж, батлах, биелэлтийг биечлэн шалгах, Хариуцсан ажлуудын ил болон далд ажлын акт үйлдэн, баталгаажуулах
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженер-1	5	3	Барилга угсралтын ажлын талбайд ХАБЭА-н дүрмийг боловсруулан өдөр тутмын хэрэгжилтийг хангаж ажиллах, Барилга угсралтын ажлын талбайд ажиллагсдын өглөөний цугларалтыг удирдан зохион байгуулж, ХАБЭА-н зааварчилгааг өгөх, Ажил эхлэхийн өмнө бүх зөвшөөрлийн баримт бичгийг хянаж, батлах, биелэлтийг биечлэн шалгах, Барилга угсралтын ажлын талбайд ХАБЭА-н үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бий болгож, үнэлэн, хөгжүүлж, хэрэгжүүлэх, Төслийн хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөө гаргаж, эрх бүхий байгууллагаар батлуулах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний явцын тайлан гаргах, хянуулах
10	Чанарын хяналтын инженер-	5	5	Барилга угсралтын ажлын талбайд буух үндсэн болон туслах материалуудад үзлэг шалгалт хийх, Барилга угсралтын ажилд

	1/Барилгын инженер болон инженерийн шугам сүлжээний инженер/			хэрэглэгдэж буй бүх материалын үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээг шалгах, бүрдүүлэх, Барилга угсралтын ажилд хэрэглэгдэж буй бүх материалын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг бүрдүүлэх, Барилга угсралтын ажилд хэрэглэгдэж буй материалуудаас барилга угсралтын ажлын талбайд сорьцыг дээжлэн авах шаардлагатай материалуудаас сорьц авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх, Төслийн барилга угсралтын ажлын ил, далд ажлын актын гүйцэтгэлийг хангах, Холбогдох норм дүрмийн дагуу хийгдэх үл эвдэх сорилыг хариуцан, тайланг захиалагчаар батлуулж, гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргах
11	Бичиг хэргийн ажилтан-1	3	2	Захиалагч болон Зохиогчийн хяналт гүйцэтгэгч нартай хийх явцын хурлыг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, хурлын шийдвэрийн биелэлтийг хянаж ажиллах, Барилгыг улсын комисст хүлээлгэн өгөхөд шаардагдах бүх баримт бичгийг бүрдүүлэх, Төслийн явцын сарын тайлан гарган захиалагчид хүргүүлэх, Ажлын зургийн бүртгэл хөтлөх, өөрчлөлтийг бүртгэх, Төсөлд оролцогч талуудтай харилцсан албан бичгийн бүртгэлийг хөтлөх
12	Байгаль орчны мэргэжилтэн-1	5	3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, барилга буулгах, угсрах ажлын явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах. Үүнд, хатуу хог хаягдал, хаягдал ус, агаарын бохирдол, дуу чимээний нөлөөлөл, олон нийтийн эмх замбараагүй байдал, аюулгүй байдалд үзүүлэх нөлөө зэрэгт тавигдах дотоодын бүхий л хууль тогтоомж, дүрэм журмууд болон АХБ-ны бодлого журам ба МУ-ын Засгийн Газар болон АХБ хоорондбайгуулсан зээлийн гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагад тусгагдсан заалтуудыг бүхэлд нь багтаан хэрэгжилтийг хангуулах.
Дээрх инженер техникийн ажилчдын 50-иас доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна.				

5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМЫН ШААРДЛАГА

5.1. Хууль, тогтоомж, стандарт

Барилгын ажлын талбайд ашиглагдах бүх тоног төхөөрөмж, машин механизм нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйлд тавьсан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Барилгын ажлын талбайд ашиглагдах өргөн зөөх, тээвэрлэх механизм нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 10 дугаар зүйлд тавьсан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

5.2. Хяналт, шалгалт, аюулгүй ажиллагаа

Ажлын талбайд ашиглагдаж буй бүх тоног төхөөрөмж, машин механизмыг зөвхөн мэргэшсэн болон жолоодох эрхийн үнэмлэх бүхий ажилтан аюулгүй ажиллагааны зааварчилгааг ХАБЭА-н ажилтнаас авсны дараа ажиллуулна.

Барилга ажлын талбайд буй бүх тоног төхөөрөмж, машин механизмыг ажил эхлэхийн өмнөх техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдсан эсэх шалгалт хийгдсэний дараа ашиглана. Тээврийн хэрэгсэл, машин механизмын бүрэн бүтэн байдлыг ХАБЭА-н төлөвлөгөөнд заасан давтамжаар, хяналтын хуудсын дагуу техникийн бүрэн бүтэн байдлын үзлэг шалгалтыг тогтмол хийж, доголдолтой машин механизмыг ажилд ашиглахгүй байх шаардлагатай.

Барилга угсралтын ажлын талбайд буй бүх тоног төхөөрөмж, машин механизмыг зөвхөн зориулалтын дагуу ашиглана. Барилга угсралтын ажлын талбайд машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийхийг хориглоно.

Тоног төхөөрөмж, машин механизмуудыг барилга угсралтын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан талбайд байлгах шаардлагатай. Гүйцэтгэгч нь тус барилгын барилга угсралтын ажлын талбайд үе шатны ажил тус бүрд шаардлагатай голлох техник, тоног төхөөрөмжийг ажиллуулсан байна.

5.3. Цамхагт краны шаардлага:

Цамхагт краныг барилга угсралтын ажлын талбайд байрлуулахдаа Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 234 дүгээр тушаалын хавсралт “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 2.18.8-р заалтын дагуу кранаар үйлдвэрлэл явуулах ажлын төслийг (ППРк) боловсруулан, мөрдөнө.
Цамхагт краны угсралтыг дээр дурдсан дүрмийн 3.2.1, 3.2.2-н заалтын дагуу тусгай зөвшөөрөлтэй компани зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь эрх бүхий байгууллагаас цамхагт кран ашиглах зөвшөөрөл авахын өмнө Захиалагчаар цамхагт краны угсралтын акт, газардуулгын акт, техникийн бүрэн магадлалын акт, техник ашиглалтын паспорт, ашиглалтын заавар, краны ашиглалтад хяналт ажилтнуудын (3 инженер) мэргэжлийн үнэмлэх зэргийг заавал хянуулна.

5.4. Ган татлагатай дүүжинт өргүүрийн /люлька, тавцан/ шаардлага:

Дүүжинт өргүүр нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 234 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн 4.1.2-р заалтын дагуу хяналтын байгууллагад бүртгэлтэй, паспорт ашиглалтын заавар болон угсралтын заавартай байхаас гадна тус дүрмийн Хавсралт 3-н шаардлага, дүрмийн 2.1.10-р заалтын шаардлагыг тус тус хангасан байна. Дүүжинт өргүүрийн консолын хийц нь тэдгээрийг гараар салгаж, зөөвөрлөх боломжтой байх нөхцөлийг хангасан байна.

5.5. Бусад тоног төхөөрөмжийн жагсаалт

Доорх хүснэгтэд үзүүлсэн тоног төхөөрөмж, машин механизмын тоо хэмжээ болон үзүүлэлт нь хамгийн бага шаардлага гэж үзнэ. Гүйцэтгэгч өөрийн ажлын зохион байгуулалт, төслийн ажлын хуваарьт үндэслэн өөрийн саналыг албан бичгээр ирүүлж, батлуулна. Ажил сайжруулах, гэрээний үүргийг хангуулахад шаардлагатай гэж үзвэл захиалагч барилга угсралтын ажлын талбайд ажиллах шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмыг Гүйцэтгэгчээс нэмж шаардаж болно.

№	Тоног төхөөрөмжийн төрөл, тодорхойлолт	Хүчин чадал	Шаардлагатай тоо хэмжээ
1	Цамхагт кран	5-8тн	1
2	Цамхагт кран	10тн	1
3	Ган татлагатай дүүжинт өргүүрийн тавцан /люлька/		1
4	Эксковатор	0.65м3	1
5	Эксковатор	1.0м3	1
6	Бульдозер	90 морины хүчтэй	1
7	Бульдозер	54/80 морины хүчтэй	1
8	Бульдозер	100/140 морины хүчтэй	1
9	Хийн дугуйт индүү	25тн	1
10	Хар тос чанадаг тогоо	500л	1
11	Автокран	5тн	1
12	Автокран	3тн	1
13	Бага оврын ачааны машин	5тн	1
14	Хүнд гөлгөр булт индүү		1
15	Зуурмаг зуурагч		1
16	Доргиурт хосолмол булт индүү	1-12тн	1
17	Гар эргүүлэг	1.5тн	1

5.6. Тээврийн зөвшөөрөл авах

БУА-ын Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцдаа, хог хаях, бараа материал тоног төхөөрөмж нийлүүлэх, бетон нийлүүлэх зэрэг хотын замаар хүнд машин механизмаар тээвэр хийхэд шаардагдах бүх зөвшөөрлийг авсан байх ба түүнтэй холбоотой хариуцлага, зардлыг бүрэн хариуцна.

6. АЖИЛ ЭХЛЭХ, ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ

6.1. Ажил эхлэх зөвшөөрөл

Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажил гүйцэтгэх зөвшөөрлийг мөрдөгдөж буй хууль, журмын дагуу авах үүрэгтэй.
Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх үе шат бүрт тохирох АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ(1), АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ(2), ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ(3), ХАБЭА-Н ТӨЛӨВЛӨГӨӨ(4) болон ТАЛБАЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГ(5) боловсруулж Захиалагчаар батлуулснаар ажил эхлэх зөвшөөрөл авна. Төлөвлөгөөг үе шаттай хийж болох ба тухайн үе шатны ажил эхлэхээс 7 хоногийн дотор ирүүлсэн байна. /БНбД 12-01-09 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт, Дэд бүлэг 6.7/

6.2. Тэг тэнхлэг тавих

Гүйцэтгэгч нь тэг тэнхлэг болон хатуу цэгийг актаар геодезийн мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж актаар баталгаажуулан хүлээн авч, өөрийн хариуцсан барилгын хяналтын түр болон хатуу цэгүүдийг байгуулсан байна.

6.3. Ажил Гүйцэтгэх Төлөвлөгөө

Гүйцэтгэгч нь Захиалагчийн төсөл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөтэй уялдуулан Ажил гүйцэтгэх төлөвлөгөөний (АГТ) нарийвчлан боловсруулж Захиалагчаар батлуулна. Энэхүү ажил гүйцэтгэх төлөвлөгөөг АХБ ны төслийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө болон бусад төслийн хүрээнд хийгдэх бусад ажлууд уялдуулсан байна.

6.4. Ажил Гүйцэтгэх Аргачлал

/БНбД 12-01-09 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт, Дэд бүлэг 6.8/

Гүйцэтгэгч нь ажлын зураг, ТЕШ, ТТШ-уудтай нарийвчлан танилцаж түүнд тохирсон технологийг сонгон аргачлал боловсруулж Захиалагчаар батлуулна. Ажил гүйцэтгэх аргачлалд дараах зүйлсийг тусгасан байх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Аргачлалын зориулалт, хэрэглэгдэх хүрээ
- Тухайн ажлыг батлагдсан хугацаанд, шаардлагын дагуу гүйцэтгэх боломжтой хүчин чадал болон техник үзүүлэлт бүхий машин механизмын сонголт, тэдгээрийн жагсаалт
- Мөн ажиллах хүчний төлөвлөлт ажил үүргийн хуваарь
- Угсралтын өргүүрийг техник-эдийн засгийн үзүүлэлтээр нь сонгох тооцоо.
- Машин механизмын хөдөлгөөнийг зохицуулсан талбайн зохион байгуулалтын зураг
- Ажлын гүйцэтгэл хөтлөх маягтууд
- Ажлын тайлангийн маягтууд
- Чанарын хяналт
- Аюулгүйн ажиллагааны дүрэм

Гүйцэтгэгч нь цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд (хэт халуун, хүйтэн нөхцөл, хэт хуурай болон чийгтэй) барилгын ажлыг (буцаан дүүргэлт, бетоны ажил, ус тусгаарлалт гэх мэт) гүйцэтгэхээр бол аргачлал боловсруулж Захиалагчаар батлуулснаар гүйцэтгэх ба түүнтэй холбоотой бүх зардлыг хариуцна.

6.5. Чанарын хяналтын төлөвлөгөө

Гүйцэтгэгч нь техникийн ерөнхий болон тусгай шаардлагыг хангахуйц Чанарын хяналт/чанарын баталгааны төлөвлөгөөг ажлын графиктай уялдуулан боловсруулж батлуулна. Уг төлөвлөөнд дараах зүйлсийг тусгасан байх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Чанарын хяналт гүйцэтгэх баг, ажиллагсад мэргэжилтнүүдийн жагсаалт, ажил үүргийн хуваарь
- Хэмжилтийн багажны жагсаалт, хэмжилт хийх аргачлал
- Буурь хөрсөнд даацын тест хийх аргачлал
- Буцаан дүүргэлтийн ажил эхлэхийн өмнө түүнд хэрэглэх материалд Техникийн Тусгай Шаардлагын дагуу хийгдсэн лабораторийн шинжилгээний үзүүлэлтүүд
- Буурь хөрс болон буцаан дүүргэлтэнд нягтаршилтын тест хийх аргачлал Туршилт, тестүүдийг туслан гүйцэтгэгч–хөндлөнгийн лабораториор хийлгэх бол түүний танилцуулга.

- Бусад техникийн тусгай шаардлагын дагуу чанарын хяналт, тэмдэглэл хийх маягтууд

6.6. Барилгын үе шатны ажлын зөвшөөрөл

Гүйцэтгэгч нь барилгын ажлын зургийг бүрэн судалсны дараа барилга угсралтын ажлыг эхлүүлэх ёстой. Ажлын зургийн иж бүрдэлд тодорхой тусгагдаагүй, хоорондоо зөрүүтэй зүйлс гарвал Гүйцэтгэгч тэр даруй зохиогчийн хяналт гүйцэтгэгчид албан бичгээр хандан тодруулга болон нэмэлт мэдээлэл авна. Энэхүү албан бичгийн хувийг Захиалагчид хүргүүлнэ. Ажлыг гүйцэтгэх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг Захиалагчийн төлөөлөгч, зохиогчийн хяналт гүйцэтгэгч нарт үзүүлэх шаардлагатай. Техникийн шаардлага хангасан гэж үзвэл холбогдох газруудаас туршилт, тохируулга хийлгэх зөвшөөрлийг авч ил, далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг үйлдсэнээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрөл олгогдоно.

7. АЖЛЫН ЗУРАГ, ТӨСЛИЙН БИЧИГ БАРИМТ

7.1. Талбайн бичиг баримт

Гүйцэтгэгч нь батлагдсан ажлын зураг, өөрчлөлтийн зураг, ИГД, техникийн нөхцөл, шаардлага, АХБ ны төслийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө, талбайн журам, төслийн ХАБЭА-н журам, талбайн даалгавар, дүгнэлт гэх мэт Захиалагчаас ирүүлсэн бичиг баримтыг талбайн оффистоо эмх цэгцтэй хадгалж ашиглалтанд бэлэн байлгана.

Төслийн БУА ыг гүйцэтгэхэд ашиглах Чанарын хяналтын хуудас, Материалын загвар батлуулах хуудас, Хяналт гүйцэтгэх хүсэлтийг маягт, Тодруулах хуудас болон бусад төслийн үйл ажиллагаанд ашиглах бичиг баримтын загварыг төслийн холбогдох Зохиогч, Захиалагчийн багтай хэлэлцэж батлагдсан маягтыг ашиглаж, бүртгэлийг эмх, цэгцтэй хөтөлж байна.

7.2. Гүйцэтгэгчийн бичиг баримт

Гүйцэтгэгч нь өөрийн бичиг баримт болох ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, чанарын төлөвлөгөө, ХАБЭА төлөвлөгөө, чанарын хяналтын хуудсууд, ажлын талбайн журнал, ил далд ажлын актууд, тест туршилт хийсэн актууд зэрэг бичиг баримтыг эмх цэгцтэй дугаарлан хавтаслаж талбайн оффистоо бэлэн байлгана.

7.3. Гүйцэтгэгчийн хийх зураг

Гүйцэтгэгч нь батлагдсан ажлын зураг төслөөс өөрчлөгдсөн ажил бүрт Тодруулгыг хүсэлтээр зөвшөөрөл авч гүйцэтгэлийн зургийн боловсруулж зохиогч (ЗТЗ), захиалагчаар батлуулсанаар ажлыг гүйцэтгэнэ. Тухайн ажил эхлэхийн өмнө зурж, батлуулснаар ажил гүйцэтгэх зөвшөөрөл авна.

8. МАТЕРИАЛЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

8.1. Стандарт

ТТШ-д өөрөөр зааснаас бусад тохиолдолд барилгын бүх материал болон ажлын гүйцэтгэл, тэдгээрийг шалгах туршилтууд нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм дүрмийн дагуу хийгдэнэ.

ТТШ-д ямар нэг үйлдвэрлэгч болон брендийн нэр заасан бол энэ нь зөвхөн жишиг материал тоног төхөөрөмжийг илэрхийлж байгаа бөгөөд ижил болон илүү чанартай бүтээгдхүүн ашиглахыг зөвшөөрнө.

8.2. Материал тоног төхөөрөмж /Загвар/ батлуулах

Гүйцэтгэгч нь барилгын архитектурын ажил, гадна дотор заслал, ИШС-ний ажилд хэрэглэх материал, тоног төхөөрөмжийн техникийн мэдээлэл, ТТШ-д заасан бол загварыг Зохиогч, Захиалагчид хүргүүлж батлуулсан байна. Зохиогч, Захиалагчийн баталсан маягтын дагуу Загвар батлуулах хүсэлтийг ирүүлнэ.

Батлуулаагүй материал тоног төхөөрөмжийг захиалах, худалдаж авах, барилгад хэрэглэхийг хориглоно.

Гүйцэтгэгч нь батлуулах Загварын жагсаалт, тэдгээрийг Захиалагчид хүргүүлж батлуулах графикийг гэрээ хийгдсэнээс 1 сарын дотор ирүүлнэ. Графикийг боловсруулахдаа үйлдвэрлэх, тээвэрлэх хугацаа ажил эхлэх хугацаа зэргийг нарийн тооцсон байна. Загвар батлуулахтай холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Ажил эхлэхээс дор хаяж 60 хоногийн өмнө Загварыг батлуулсан байна. Загвар батлуулахтай холбоотой хугацаа хоцрох эрсдлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

Гүйцэтгэгч нь Зохиогч ба Захиалагчийн заасан газар загварын өрөө гаргаж батлагдсан бүх загварыг ажил дуусах хүртэл хадгална. Загвар бүрийн дээр тэдгээрийн хэрэглэх газар, дугаар зэргийг тодорхой илэрхийлсэн хаяг наасан байна.

8.3. Гүйцэтгэлийн загвар батлуулах

Гүйцэтгэгч нь дараах үндсэн ажил эхлэхээс өмнө дараах ажлуудыг талбай дээр 1:1 хэмжээгээр угсарч Захиалагч/ТМБ-аар батлуулсан байна. Үүнд:

a) Цонх, түүний эргэн тойронд 50см-с доошгүй өргөнтэй дулаалга, хар шавар, усны хаялга, цонхны тавцангийн хамт угсрах

8.4. Батлагдаагүй загвар

Хэрэв ирүүлсэн Загвар болон гүйцэтгэлийн загвар батлагдаагүй бол түүнийг бүх холбогдох бичиг баримтын хамт талбайгаас зайлуулах ба түүнтэй холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

8.5. Материалын хадгалалт хамгаалалт

Гүцэтгэгч нь барилгын талбайд ирүүлсэн бараа материалын (тухайн барилгад зориулж Захиалагчийн болон түүний Нэрлэсэн ханган нийлүүлэгчийн нийлүүлж хүлээлгэж өгсөн бараа материалыг оролцуулан) бүрэн бүтэн байдлыг хариуцна.

Гүйцэтгэгч, түүний ажиллагсдын буруугаас бараа материал эвдэрч гэмтсэн бол тэрээр өөрийн зардлаар богино хугацаанд барилгын талбайд нөхөн авчрана.

9. ЧАНАРЫН ХЯНАЛТ

9.1. Тест, туршилтууд

Гүйцэтгэгч нь БУА-ын үе шат бүрт ажлын чанарыг баталгаажуулах тест туршилтуудыг ТТШ-т өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, БНбД-д заасны дагуу, Зохиогч ба Захиалагчийн төлөөлөгчийг байлцуулан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь дээрх тест туршилт, хяналт шалгалтын үр дүнг Зохиогч ба Захиалагчаар батлуулснаар дараагийн үе шатны ажил гүйцэтгэх зөвшөөрөл авах, дундын болон сүүлийн төлбөрийн мэдэгдэл авах эрх бүрдэнэ. Тест, туршилттай холбогдон гарах бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

9.2. Хэмжилт

Гүйцэтгэгч нь Техникийн Тусгай шаардлагад заасан хэвтээ, босоо хэмжээг хүлцэх алдааны хүрээнд чанд баримтлан гүйцэтгэнэ. Хэмжилт хийхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмж хүн хүчийг ажиллуулна. Хэмжилтийн ажлыг гүйцэтгэх инженер нь геодезийн инженер эсвэл сертификат бүхий геодезийн техникч байх ба дараах ур чадварыг хангасан байна:

- Төслийн талбайн геодезийн үндэслэл сүлжээний цэгүүдээс хэмжилт хийн үндэслэл сүлжээг өтгөрүүлэх,
- Тэг тэнхлэг тавих шалгах, байрзүйн болон өндрийн хяналт хэмжилтийг гүйцэтгэж чаддаг байх.

Ажлын явцад хөндөгдөхөөргүй байршлыг сонгож хэмжилтийн цэгүүдийг байгуулж ажиллана. Гүйцэтгэгч нь барилга угсралтын явцад барилгын суулт болон хазайлтыг хэмжих аргачлалыг боловсруулж батлуулан хэрэгжүүлнэ. Цутгалт бүрийн дараа гүйцэтгэлийн хэмжилт хийж хянуулснаар дараагийн цутгалт хийгдэнэ.

10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛГӨӨ (Г-БОМТ)

10.1. Зорилго

Гүйцэтгэгчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (Г-БОМТ)-ний зорилго нь барилгын ажлын явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах/арилгах, хянах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино. Мөн үүнд байгаль орчны чиглэлийн өдөр тутмын асуудлуудыг шийдвэрлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг хариуцах хүн, байгаль орчны нөхцөлийг хэн хэрхэн хянах болон Г-БОМТ-тэй нийцэж байгааг эсэхийг Гүйцэтгэгч тал хэрхэн хяналт тавих тухай тусгана.

10.2. Тавигдах шаардлага

Г-БОМТ-г боловсруулахдаа төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллүүд дээр үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан журам, мөн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушуулаар батлагдсан аргачлалыг баримталж, Төслийн Байгаль Орчны Урьдчилсан Үнэлгээ (БОУҮ), Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө (БОМТ), Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ (БОННҮ) болон БОАЖЯ-ны бусад дүрэм журмын хяналтын шаардлагуудтай уялдуулан боловсруулна.

10.3. Тайлагнал

- Г-БОМТ-ний анхны хувилбарыг гэрээнд гарын үсэг зурснаас 10 хоногийн дотор, эцсийн хувилбарыг 28 хоногийн дотор Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-д хүлээлгэж өгнө.
- Хэрэв тухайн ажил тухайн жилийн 9 дүгээр сарын 20-ны дотор дуусаагүй бол Г-БОМТ-ний биелэлтийн явцын тайланг тухайн оны 09-р сарын 20-ны дотор, эцсийн тайланг барилгын ажил дууссанаас хойш 15 хоногийн дотор Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлнэ.

Байгаль орчны мэргэжилтэн нь дараах ажил үүргийг хариуцан хийж гүйцэтгэнэ:

- Төсөлд хийгдсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Байгаль орчны урьдчилсан үнэлгээ, МУ-ын байгаль орчны талаарх холбогдох хууль, журмууд зэрэг бичиг баримттай дэлгэрэнгүй танилцсаны үндсэн дээр Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлөн Г-БОМТ-г боловсруулах;
- Г-БОМТ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Барилгын ажил явуулахад шаардагдах байгаль орчны холбогдох зөвшөөрлүүдийг авах;
- Барилгын ажлын талбай болон ажилчдын түр кэмпийн орчинд байгаль орчны хамаарал бүхий асуудлуудыг шийдвэрлэх;
- Г-БОМТ-ийн биелэлтийн явцын болон эцсийн тайланг бэлтгэх;
- Төсөл хэрэгжүүлэх нэгж болон Захиалагчаас байгаль орчны чиглэлээр өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг биелүүлж ажиллах.

10.4. Бусад шаардлагууд

БОАЖЯ-наас шаардлага тавьсан тохиолдолд, Гүйцэтгэгч нь өөрийн гэрээгээр хариуцаж авсан барилгын багцад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллага хөлслөн хийж гүйцэтгүүлэх үүргийг хүлээнэ.

11. ДААТГАЛ

БУА-ын Гүйцэтгэгч нь хамгийн багадаа дор дурдсан даатгалд хамрагдсан байх шаардлагатай.

a. Ажиллагсдын даатгал

   Гүйцэтгэгч нь хамгийн багадаа бүх ажиллагсдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд, жолооч операторуудыг хариуцлагын даатгалд хамруулсан байна.

b. Машин менанизмын үзлэг, даатгал

   Гүйцэтгэгч нь барилгын талбайд ажиллах бүх машин механизмыг зохих үзлэг болон даатгалд хамруулсан байна

Гүйцэтгэгч нь Захиалагчийн гэрээнд заасан барилгын ажил гүйцэтгэх даатгалыг мэргэжлийн байгууллагатай байгуулах үүрэгтэй.

12. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

12.1. Гэрээний үнэ

Гүйцэтгэгч нь ТЕШ-ын 2-р зүйлд заасан ажлын задаргааны дагуу үнийн саналаа ирүүлнэ. Үнийн санал боловсруулахдаа ТЕШ болон ТТШ заасан зардлуудыг тусгасан байна.

Гэрээний үнэд ямар ч нөхцөлд өөрчлөлт орохгүй. Цалингийн хөлсний үнэ, материалын үнэ, валютын ханш, тээврийн зардал, татварын хураамжийн үнийн өөрчлөлт нь Гэрээний үнэд өөрчлөлт орох үндэслэл болохгүй.

12.2. БУА-ын тоо хэмжээ, үнийн санал

Гүйцэтгэгч нь ажлын зурагтай сайтар танилцаж, тендерийн бичиг баримт дахь ажлын тоо хэмжээг нягтлан шалгасны үндсэн дээр үнийн саналыг ирүүлнэ. Тендерийн бичиг

баримтын ажлын тоо хэмжээ, батлагдсан зургаас зөрсөн нөхцөлд тодруулах шаардлагатай эс бөгөөс ажлын зураг төслийн дагуу ажлын тоо хэмжээг тооцно. Ажлын тоо хэмжээнд гарсан аливаа алдаа нь гэрээнийн үнэд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

12.3. Гэрээний үнэд орох бусад зардал

Гүйцэтгэгч нь аливаа хууль тогтоомжтой холбоотой төсөв, татвар хураамж зэргийн үнийг тооцож үнийн саналаа ирүүлнэ. Үүнд:

- НӨАТ, ХАОАТ, Нийгмийн даатгалын шимтгэл
- Нормчлолын сан
- ХАБЭА-н зардал
- Туршилт тохируулгын үед төрийн байгууллагад төлдөг хураамж
- Аймаг болон сумын төвийн замаар тээвэр хийхтэй холбоотой хураамж

гэх мэт

Гүйцэтгэгч нь эдгээр үнийн дүнг үнийн саналдаа тусгайлан заагаагүй бол нийт үнэд багтсан гэж тооцно.